



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/19

Даланзадгад сум

“Сум дундын ойн анги”-ийн
жагсаалт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 201 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах “Сум дундын ойн анги”-ийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан жагсаалтын дагуу “Сум дундын ойн анги”-ийг үе шаттай байгуулж, бүтэц, орон тоо, дүрмийг батлан, үйл ажиллагааны зардлыг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
5/19 дүгээр тогтоолын хавсралт



Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах
“Сум дундын ойн анги”-ийн жагсаалт

д/д	Бүсчлэл	Сум дундын ойн ангийн байршил	Харьяалах сумдын нэр	Хариуцах ойн сангийн талбай /га/	
				Заган ой	Таримал ой
1	Баруун	Сэврэй сум	Гурвантэс	569614	-
2			Ноён	59074	-
3			Сэврэй	92252	-
Нийт			3 сум	720940	-
4	Төв	Даланзадгад сум	Баяндалай	74411	-
5			Булган	18834	1513 га, 1 га-заг үржүүлэг
6			Даланзадгад	-	505 га, 24 га- МҮГГазар
7			Мандал-Овоо	48435	-
8			Номгон	41722	-
9			Ханхонгор	-	-
10			Хүрмэн	86744	-
Нийт			7 сум	270146	2043
11	Зүүн	Цогт-Овоо сум	Баян-Овоо	61287	-
12			Манлай	10215	-
13			Ханбогд	116593	27
14			Цогт-Овоо	10042	-
15			Цогтцэций	3	-
Нийт			5 сум	198140	27
Сум дундын Ойн анги -3, нийт 15 сум			15 сум	1189226	2070